

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 113 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 113.6 дахь хэсэг нэмсүгэй:

“113.6.Шүүх энэ хуулийн 112.1.4, 112.1.5-д заасан маргааныг хянан шийдвэрлэж, дараахь дараахь байдлаар магадлал гаргана:

113.6.1.шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй орхих;

113.6.2.шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг хангах;

113.6.3.гомдол гаргаж буй шийдвэрийг хүчингүй болгож, маргааныг дахин шалгуулахаар шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтанд буцаах.”

2 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“112.1.4.Өмгөөллийн тухай хуулийн 8.3, 50.1-д заасан маргаан;
112.1.5.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.3, 74.4-т заасан маргаан;

112.1.6.хуулиар тусгайлан заасан бусад маргаан.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Өмгөөллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 15.28 дугаар зүйл нэмсүгэй:

“15.28 дугаар зүйл. Өмгөөллийн тухай хууль зөрчих

1. Гадаад улсын өмгөөлөгч Монгол Улсад өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх журмыг зөрчсөн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Өмгөөлөгчийн хүсэлтэд хариу өгөөгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Иргэний хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангах үүргээ биелүүлээгүй, эсхүл уг эрхээ хэрэгжүүлэхэд өмгөөлөгч болон түүний үйлчлүүлэгчээс хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ, түүний хуулбарыг шаардсан, эсхүл хууль зүйн мэргэжлийн туслалцаа хүсэгчид тодорхой өмгөөлөгчийн нэр заах, үйлчилгээг нь авхуулахаар тулгасан бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Өмгөөллийн нууцыг хадгалах үүрэгтэй этгээд уг нууцыг хууль бусаар задруулсан, эсхүл хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын тулд ашигласан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Өмгөөлөгчөөс өмгөөллийн үйл ажиллагаагаа эрхлэх болон үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг хязгаарласан буюу түүнээс хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь дарамт шахалт үзүүлсэн, саад учруулсан, баталгаа шаардсан, заналхийлсэн, эсхүл бусад байдлаар хөндлөнгөөс нөлөөлсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Өмгөөллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Өмгөөллийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн хуульчдын бүртгэлийг Улсын Дээд шүүх Өмгөөлөгчдийн холбоонд шилжүүлнэ.

2 дугаар зүйл. Өмгөөлөгчдийн Холбооны анхдугаар Их хурлыг Өмгөөллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 180 хоногийн дотор хуралдуулах бөгөөд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

3 дугаар зүйл. Өмгөөлөгчдийн Холбооны анхдугаар Их хурал 300 хүртэл өмгөөлөгчийн төлөөлөлтэй байх бөгөөд төлөөлөгчдийг 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуульчдын нэгдсэн бүртгэлд хамрагдсан хуульчдаас сонгон оролцуулах бөгөөд сонгох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4 дүгээр зүйл. Өмгөөлөгчдийн Холбооны анхдугаар Их хурлыг зохион байгуулах зардлыг Засгийн газар хариуцна.

5 дугаар зүйл. Монголын өмгөөлөгчдийн холбоо төрийн бус байгууллагын хөрөнгийг Өмгөөллийн тухай хуулийн дагуу байгуулагдсан Өмгөөлөгчдийн холбоонд шилжүүлэх ажлыг Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

6 дугаар зүйл. Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын асуудал эрхэлсэн хороо шинээр зохион байгуулагдах хүртэлх хугацаанд өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийн талаархи маргааныг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл. Энэ хуулийг Өмгөөллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил, шалган шийдвэрлэх тухай хуулийн 18.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “хэсэгт заасан зөрчил” гэснийг “хэсэг, 15.28 дугаар зүйлд заасан зөрчил” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Өмгөөллийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг